

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Орон нутагт төрийн байгууллагын хүний нөөцийн
бодлого, стратеги батлагдаагүй, хяналтын үр
нөлөөтэй тогтолцоо бүрдээгүй байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого,
тогтолцооны үр нөлөө

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/19-ШТА-ГА
ДОА-2024/19-9-ШТА-ГА

Чойбалсан хот 2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайланг бэлтгэсэн:

Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газар

Аудитын II баг

Дарга, Тэргүүлэх аудитор
Б.Болортуул

Ахлах аудитор:
Я.Зориг

Аудитор:
С.Энхбаатар

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 7058-4203, 7058-
4207 утсаар лавлана уу.

Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн
сум, 7-р баг, аймгийн ЗДТГ-
ын 4-р давхарт 03 тоот

2024 оны 11 дүгээр сар

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгт, дүрслэлийн товъёг.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	6

Бүлэг 1. Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого төлөвлөлт,
хөтөлбөрийг батлаагүй, хэрэгжүүлэх тогтолцоо бүрдээгүй
байна.....7-20

1.1. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагын хүний нөөцийн
нэгдсэн бодлого, хөтөлбөрийг батлаагүй, урт, дунд
хугацааны бодлогын баримт бичгийн үр нөлөөг тооцоогүй
байна.....7-11

1.2. Төрийн байгууллагын хүний нөөцийн хүрэлцээгүй
байдал нь төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд сөргөөр
нөлөөлж байна.....11-15

1.3. Төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, хүний
нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох шаардлагатай
байна.....15-20

Бүлэг 2. Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоог
боловсронгуй болгох шаардлагатай байна.....21-26

2.1. Иргэндээ үйлчилдэг мэргэшсэн, чадварлаг ил тод төрийн
алба төлөвшөөгүй байна.....21-24

2.2. Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран авах
нөхцөл боломж бүрдсэн боловч үйлчилгээ жигд, хүртээмжтэй
хүрч чадахгүй байна.....25

2.3. Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд хяналт
тавих тогтолцоо бүрдээгүй байна.....25-26

ДҮГНЭЛТ, АУДИТЫН ДҮН:	27-28
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР.....	29
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:	30
ЗӨВЛӨМЖ:	31
ТУШААЛ:	32-33
ХАВСРАЛТ:	

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
АТТ	Албан тушаалын тодорхойлолт
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем
ДОА	Дорнод аймаг
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МАОУТҮБХМ	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, үржил, бүртгэл хариуцсан мэргэжилтэн
МУ	Монгол Улс
НЗБ	Нутгийн захиргааны байгууллага
НӨУБ	Нутгийн өөрөө удирдах байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
СӨБ	Сургуулийн өмнөх байгууллага
СС	Сангийн Сайд
СҮЗ	Стандартчиллын үндэсний зөвлөл
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТАХ	Төрийн албан хаагч
ТЖАХ	Төрийн жинхэнэ албан хаагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗ	Төрийн захиргаа
ТҮ	Төрийн үйлчилгээ
УАУТ	Уламжлалт анагаах ухааны төв
УТ	Улс төр
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Хөдөө аж ахуй
ХДТ	Хөгжимт драмын театр
ХЭГ	Хэрэг эрхлэх газар
ШТА	Шууд тайлагналын аудит
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
MNS	Mongolian national standard

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд төрийн байгууллагын хүний нөөц, засаглалын бодлоготой холбоотой тусгагдсан зорилт, арга хэмжээ	7
Хүснэгт 2	НӨУБ, НЗБ-ын бүтэц, орон тооны хязгаар	8
Хүснэгт 3	Төрийн үйлчилгээний байгууллагын бүтэц, орон тооны норм, норматив	10
Хүснэгт 4	Аудитаар илэрсэн зөрчил, байгууллагаар	16
Хүснэгт 5	Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрт зарцуулсан төсөв (сая төгрөг)	17
Хүснэгт 6	Төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд хохирол учруулсан тоо мэдээ, 2014-2024 он	19
Хүснэгт 7	Төрийн албан хаагчдыг сургалтад хамруулсан байдлын судалгааг 2021-2023 оноор хүснэгтээр үзүүлбэл:	20
Хүснэгт 8	Аймаг, сумын ЗДТГ-ын албан хаагчдын хүйсийн харьцаа	22
Хүснэгт 9	Хүйсийн харьцааны тоон мэдээлэл	22-23

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Аймаг, сумдын ЗДТГ-ын бүтэц орон тоо /2024.09.30-ны байдлаар/	9
Дүрслэл 2	Аймаг, сумын ИТХ-ын бүтэц орон тоо /2024.09.30-ны байдлаар/	9
Дүрслэл 3	Хүний нөөцийн хүрэлцээ /НӨУБ/	12
Дүрслэл 4	Хүний нөөцийн хүрэлцээ /ТЗ/	12
Дүрслэл 5	Хүний нөөцийн хүрэлцээ /Соёл/	12
Дүрслэл 6	Хүний нөөцийн хүрэлцээ /Боловсрол/	12
Дүрслэл 7	Хүний нөөцийн хүрэлцээ /Эрүүл мэнд/	13
Дүрслэл 8	Хүний нөөцийн хүрэлцээ /ТӨҮГ болон ОНӨААТҮГ/	13
Дүрслэл 9	Санал асуулгын дүн	14
Дүрслэл 10	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн сул орон тоог нөхөн бүрдүүлсэн байдал	18

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: - Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн эсэх; - Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитаар төрийн зорилт, чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлдэг төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа явуулдаг бүтэц, зохион байгуулалттай төрийн захиргааны, тусгай, үйлчилгээний байгууллагуудын хүний нөөцийн, бодлогын, хяналт шинжилгээ дотоод аудитын албад нь өөрийн болон өөрт хамаарах байгууллагуудын хүний нөөцийн бодлогыг оновчтой зөв тодорхойлсон, боловсруулсан, баталгаажуулсан байдлыг үзэж шалгалаа. Аудитад Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймаг дахь салбар зөвлөл болон төрийн байгууллагуудын 2012-2023 оны хүний нөөцийн үйл ажиллагааг хамруулсан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон төрийн байгууллагуудын хүний нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. - Тухайн аудитын зорилтыг хангахад чиглэсэн аудитын асуудлын шинжилгээнд тусгагдсан асуултууд (Хавсралт 2) - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль - Төрийн албаны тухай хууль

**Аудитын
бүрэлдэхүүн, хугацаа**

- Авлигын эсрэг хууль
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Байгууллагын нууцын тухай хууль
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Нийтийн ил тод байдлын тухай хууль
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- Төрийн болон албаны нууцын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн байгууллагын хүний нөөцийн бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Я.Зориг, аудитор С.Энхбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Аудитын явцад эрх бүхий этгээдийн шийдвэрээр багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж болно.

Аудитын дэд төлөвлөгөөг 2024 оны 8 дугаар сарын 26-ны дотор батлуулж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж хэлэлцүүлэн, тайлан, холбогдох судалгааг 11 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨТӨЛБӨРИЙГ БАТЛААГҮЙ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

1.1. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагын хүний нөөцийн нэгдсэн бодлого, хөтөлбөрийг батлаагүй, урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийн үр нөлөөг тооцоогүй байна.

1.1.1. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг боловсруулж, батлаагүй байна.

Монгол Улсын Их хурлын 2000-2019 оны тогтоолуудаар төрийн тусгай чиг үүргийн зарим байгууллагуудын зохион байгуулалтын бүтэц, Засгийн газрын 1997-2024 оны тогтоолуудаар зарим яам, агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг тус тус баталсан байна.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 07 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийг баталж, 2023 оны 71, 72 дугаар тогтоолоор тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Харин Нутгийн захиргааны байгууллагын стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр гэж батлагдан гараагүй. Харин урт хугацааны “Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт”, дунд хугацааны “Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 онуудын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийг баталж, төрийн байгууллагын засаглал, хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгаа зэрэг асуудлыг тусгасан байна.

Хүснэгт 1. “Урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд төрийн байгууллагын хүний нөөц, засаглалын бодлоготой холбоотой тусгагдсан зорилт, арга хэмжээ”

Он	Бодлогын баримт бичиг	Тусгагдсан зорилт, арга хэмжээ
2016-2025	Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт	1. Бодлог чиглэл 3. Аймгийн засаглалын чадавхыг бэхжүүлж, хөгжлийн удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог сайжруулна. 2. Зорилт 7. Орон нутгийн засаглалын чадавхыг бэхжүүлж, төрийн байгууллагуудын ажлын уялдааг сайжруулна. /Задарсан 8 заалт/ Мөн төрийн байгууллагын албан хаагчдыг сургаж, хөгжүүлж, чадавхжуулах заалтууд тусгагдсан байна.
2021-2025	Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	1. Зорилт 6. Засаглал. 6.1. Ухаалаг засаглал, 6.2. Ухаалаг бүтэц, 6.3. Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба
2016-2020	Дорнод аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Зорилт 2.2. Багш болон боловсрол, соёлын ажилтны хөгжил, Зорилт 1.1. Нутгийн удирдлагын хүрээнд /6 заалт/
2020-2024	Дорнод аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Зорилт 4. Засаглалын бодлого /Бүх шатны төрийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэн, иргэд олон нийтэд төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй хүргэнэ.

Эх сурвалж: Аймгийн урт, дунд хугацааны батлагдсан бодлогын баримт бичгүүд

Монгол Улсын Засгийн газрын “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 2021 оны 377 дугаар тогтоолоор АЗДТГ-ын бүтцийг 3 удирдлага, 6 хэлтэс, 1 штабтай, нийт 57 хүртэл орон тоотой байхаар буюу зохион байгуулалтын бүтцийг ерөнхий байдлаар баталжээ.

“Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор ЗДТГ-ын чиг үүргийн шинжилгээ хийж, аймгийн ЗДТГ-ын хэлтэс, тасаг, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах агентлагийн хооронд чиг үүргийн давхардал, хийдэл

үүсгэхгүйгээр оновчтой зохицуулалт хийж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт даалгасан боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай” 2009 оны 13 дугаар тогтоолоор сумдын ЗДТГ-ын орон тооны хязгаарыг 13-23 байхаар баталсан байна. Тус тогтоолоор сумын ЗДТГ-ын зохион байгуулалтын бүтцийн талаар санал боловсруулан ЗГХЭГ-тай зөвшилцөн баталж мөрдүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгасан боловч хэрэгжүүлээгүй байна.

Дүгнэлт: Орон нутгийн түвшинд төрийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги батлагдан гараагүй, аймаг, сумын ЗДТГ-ын зохион байгуулалтын бүтцийг ЗГ-ын тогтоолд нийцүүлэн боловсруулж, батлаагүй байна. Аймгийн дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан засаглал, хүний нөөцийн бодлого нь улсын хөгжлийн бодлоготой нийцсэн байна.

1.1.2. Батлагдсан бүтэц, орон тооны хязгаарыг зарим төрийн байгууллагууд мөрдөн ажиллахгүй байна.

Орон нутгийн түвшинд төрийн захиргааны байгууллагуудад батлагдсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц байхгүй байна.


Харин нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллагын бүтэц, орон тооны хязгаарыг баталсан байна.

Хүснэгт 2. “НӨУБ, НЗБ-ын бүтэц, орон тооны хязгаар”

№	Шийдвэрийн нэр	Утга	Огноо, дугаар	Бүтэц, орон тоо
1	Засгийн газрын тогтоол	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай	2021.12.14 377	57 хүртэл
2	Засгийн газрын тогтоол	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны бүтэц, аймаг, сумын ИТХ-ын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай	2021.12.14 376	Аймаг 10, сум 3 хүртэл
3	Засгийн газрын тогтоол	Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай	2009.01.14 13	16-23 хүртэл

Эх сурвалж: www.legalinfo.mn


Дүрслэл 1. “Аймаг, сумдын ЗДТГ-ын бүтэц орон тоо /2024.09.30-ны байдлаар/”



Эх сурвалж: ТАХ-дын нэгдсэн судалгаа, гүйцэтгэл

Дээрх дүрслэл харахад аймаг, сумдын ЗДТГ-ын орон тоо нь батлагдсан орон тооноос 1-17 орон тоогоор дутуу байгаа боловч ЗГ-аас тогтоосон бүтэц, орон тооны хязгаараас 5-58 орон тоогоор илүү байна. Энэ нь ЗГ-аас тогтоосон орон тооны хязгаар нь ерөнхий байдлаар батлагдаж, ЗДТГ-т ТЖАХ болон УТ, ТҮ-ний албан хаагчдын тоог нарийвчлан зааж өгөөгүй байгаатай холбоотой байна.

Дүрслэл 2. “Аймаг, сумын ИТХ-ын бүтэц орон тоо /2024.09.30-ны байдлаар/”



Эх сурвалж: ТАХ-дын нэгдсэн судалгаа, гүйцэтгэл

Дүрслэл 2-оос харахад аймгийн ИТХ-ын ажлын алба нь ЗГ-аас баталсан бүтэц, орон тооны хязгаараас 5 орон тооны хэтрэлттэй явж байна.

Боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, орон тооны жишиг нормативыг Монгол Улсын стандарт, сайдын тушаалаар баталсан байна.

Хүснэгт 3. “Төрийн үйлчилгээний байгууллагын бүтэц, орон тооны норм, норматив”

№	Шийдвэрийн нэр	Утга	Огноо, дугаар	Бүтэц, орон тоо
Боловсролын байгууллага				
1	БСШУС, СС-ын хамтарсан тушаал	Багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив	2018.01.23 А/024/11	Хүчин чадлаас хамаарч 2-4
2	БШУС, СС-ын хамтарсан тушаал	Хүүхдийн цэцэрлэг, түүний дэргэдэх салбар бүлгийн орон тооны хязгаарын жишиг норматив	2024.02.26 А/85 А/34	Хүчин чадлаас хамаарч янз бүр
Соёлын байгууллага				
3	СҮЗ-ийн тогтоол	Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Соёлын төв, соёлын ордон. Орчин бай үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага. MNS 6981:2022	2022.10.11 42	11-19
Эрүүл мэндийн байгууллага				
1	СҮЗ-ийн тогтоол	Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа. MNS 5081:2013	2013.12.19 63	Хүн амын тоо, хүчин чадлаас хамаарна.

Эх сурвалж: www.moe.gov.mn, www.estandart.gov.mn

Аймгийн хэмжээнд боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд нь салбарын хэмжээнд батлагдан гарсан бүтэц, орон тооны жишиг норм, нормативыг баримталсан байна.

Харин батлагдсан орон тооноос дутуу ажиллаж байгаа нь тухайн албан тушаалд мэргэжилтэй албан хаагч олдохгүй, хүний нөөцийн хомсдол үүссэнтэй холбон тайлбарлаж болох юм.

Дүгнэлт: ЗГ-аас тогтоосон бүтэц, орон тооны хязгаар нь ерөнхий байдлаар батлагдсанаас шалтгаалж, ЗДТГ-ын орон тоо харилцан адилгүй батлагдаж, хязгаараас хэтэрсэн байдалтай байна.

1.1.3. Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх олон талын уялдаа холбоо хангагдаж, биелэлтэд ахиц, дэвшил гараагүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1¹-д хөгжлийн бодлого, төлөвлөлт нь нэгдмэл, цогц, харилцан уялдаатай, тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх зарчмуудыг баримтлахаар тусгасан байна.

Аймгийн хэмжээнд 2013-2024 оныг хүртэл төрийн албан хаагчийн бодлого, тогтолцоог сайжруулахад чиглэсэн хүний нөөцийн бодлогын баримт бичиг батлагдан гараагүй тул бодлогын зорилтыг хэрэгжүүлэх олон талын уялдаа холбоо хангагдсан эсэхэд хариулт өгөх боломжгүй байна. Харин аймгийн ИТХ-ын 2017 оны 01 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих” хөтөлбөрийг баталсан боловч 2017-2021 оныг хүртэл хэрэгжиж дууссан байна.

Дүгнэлт: Хүний нөөцийн бодлогын зорилтын хэрэгжилт нь нэгдмэл, цогц, харилцан уялдаатай, тасралтгүй байх зарчмыг хангахгүй байгаа бөгөөд биелэлтэд ахиц дэвшил гараагүй байна.

1.1.4. Төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-үнэлгээ хийж, үр нөлөөг тооцоогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баталж, тус журмын 1.3-т “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, хүний нөөцийн чадавхыг сайжруулах асуудлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар зохион байгуулна.”, 4.4-т “Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж өгөх үүрэгтэй. Бодлогын баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шатанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан, нэгжээс төлөөлөл оруулан хамтран ажиллана.” гэж тус тус заажээ.

Аймгийн урт хугацааны “Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт” бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд /засаглал, хүний нөөцийн бодлого, тогтолцооны хэрэгжилттэй холбоотой 2 зорилт, 8 заалт/, дунд хугацааны “Хүний нөөцийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хугацаа дуусаж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдээгүй, үр нөлөөг тооцоогүй байна.

Дунд хугацааны “Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Дорнод аймгийн Засаг даргын 2012-2016, 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн боловч үр нөлөөг тооцоогүй байна.

Дүгнэлт: Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-үнэлгээг хийгээгүй, үр нөлөөг тооцохгүй байгаа нь бодлогын хэрэгжилтэд тавих хяналт сул байгааг харуулж байна.

¹ 5.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална:

5.1.3. нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;

5.1.4. тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх;

1.2. Төрийн байгууллагын хүний нөөцийн хүрэлцээгүй байдал нь төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд сөргөөр нөлөөлж байна.


1.2.1. Аудитад хамрагдсан байгууллагуудын хүний нөөцийн хүрэлцээ 93.4 хувьтай байна.

Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төрийн албаны төв байгууллага төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх бөгөөд уг бүртгэлд төрийн албан тушаал эрхэлж байгаа, эрхэлж байсан мэдээлэл болон энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан удирдах албан тушаалтны нөөцийн бүртгэлийг тусгасан байна.” гэж заасан.

Аймгийн хэмжээнд 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 6 салбарын 158 байгууллагад 5550 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 92.1 хувь буюу 5183 албан хаагч ажилласан байна. Батлагдсан орон тооны гүйцэтгэлийг салбар бүрээр 2024 оны 09 дүгээр сарын байдлаар авч үзвэл:

Дүрслэл 3. “Хүний нөөцийн хүрэлцээ /НӨУБ/”

1. Нутгийн өөрөө удирдах байгууллага: Аймаг, сумын ИТХ-ын 15 ажлын албаны хүний нөөцийн хүрэлцээ 2024 оны 09 дүгээр сарын байдлаар хангалттай хэмжээнд гэж үзэж байна. Тухайлбал МУ-ын ЗГ-ын 2021 оны 376 дугаар тогтоолоор НӨУБ-ын орон тоог нэмэгдүүлснээр сумдад 1 орон тоо нэмэгдсэн байна.




2. Төрийн захиргааны байгууллага: Аймгийн Засаг даргын дэргэдэх газар, агентлаг, хэлтэс, сумын ЗДТГ, бусад төсвийн байгууллагын хүний нөөцийн хүрэлцээ 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 1230 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 1110 орон тоотой ажиллаж, батлагдсан орон тоотой харьцуулахад 90.2 хувьд хүний нөөцөөр хангагдсан байна.

Дүрслэл 4. “Хүний нөөцийн хүрэлцээ /ТЗ/”




Дүрслэл 5. “Хүний нөөцийн хүрэлцээ /Соёл/”




3. Соёлын салбар: Аймгийн Музей, ХДТ, Соёлын газар, Төв номын сан, сумдын Соёлын төвийн зэрэг 17 байгууллагын хувьд 2024 оны 09 дүгээр сарын байдлаар нийт 250 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 232 албан хаагч ажиллаж, 92.8 хувьд хүний нөөцөөр хангагджээ.

Дүрслэл 6. “Хүний нөөцийн хүрэлцээ /Боловсрол/”



4. Боловсролын салбар: Аймгийн төвийн болон сумдын сургууль, цэцэрлэгийн 52 байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 2259 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 2139 орон тоотой ажиллаж, 94.7 хувьд хүний нөөцөөр хангагдсан байна. ТЭЗ-аас ЕБС-ын багш нарын орон тооны нормативыг батлан гаргаагүй байгаа нь сургууль бүрд орон тоо харилцан адилгүй байгаатай холбоотой байна.

Дүрслэл 7. “Хүний нөөцийн хүрэлцээ /Эрүүл мэнд/”




5. Эрүүл мэндийн салбар:

Аймгийн ЭМГ, БОЭТ, УАУТ, сумдын ЭМТ зэрэг 16 байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 875 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 826 албан хаагчтай ажиллан 94.4 хувьд хүний нөөцөөр хангагдаж, хүний нөөцийн хүрэлцээ хангалтай байгаа нь сумдын ЭМТ-үүд байна.

Дүрслэл 8. “Хүний нөөцийн хүрэлцээ /ТӨҮГ, ОНӨААТҮГ/”

6. ТӨҮГ болон ОНӨААТҮГ: аймгийн хэмжээнд байгаа “ДБЭХС” ТӨХК, “Дорнод НАА” ОНӨААТҮГ, сумдын тохижилт, үйлчилгээ, ойжуулалтын ОНӨААТҮГ-уудад 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 878 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 831 орон тоотой ажиллаж, 47 орон тоогоор дутуу буюу 94.6 хувьд хүний нөөцийн хүрэлцээ хангагджээ.



Дүгнэлт: Төрийн байгууллагуудын хүний нөөцийн хүрэлцээнд хийсэн шинжилгээгээр төрийн захиргааны салбарын хүний нөөцийн хүрэлцээ 90.2 хувь, соёлын салбарын хүний нөөцийн хүрэлцээ 92.8 хувь, бусад салбарт 94.4-94.7 хувь хангагджээ.

1.2.2. Аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэрийг албан ёсны эрх зүйн мэдээллийн системд байршуулж ажиллаагүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 7-р зүйлийн 7.1-д “ард түмэнд үйлчлэх”, 7.2-т “ил тод байх”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд “Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана” гэж заасан байна.


Аудитад хамрагдсан нийт байгууллагаас 45 байгууллагыг түүвэрлэн авч, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг 2023-2024 оны хагас жилийн байдлаар авч үзэхэд аймгийн ЗДТГ, ИТХ нь албан ёсны веб сайт, фэйсбүүк хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр, сумын ЗДТГ, ИТХ нь фэйсбүүк хуудас, мэдээллийн самбараар, боловсрол, эрүүл мэнд, соёл, төрийн захиргааны байгууллагууд нь фэйсбүүк хуудсаар дамжуулан төрийн үйлчилгээг иргэдэд ил тод мэдээлсэн байна. Харин аймгийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөх, хэм хэмжээ тогтоосон аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэрийг Хууль зүйн ямаар хянуулж, төрийн албан ёсны эрх зүйн мэдээллийн систем www.legalinfo.mn цахим сайтад байршуулаагүй байна.

Аймгийн хэмжээнд иргэний бүртгэлийн үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан цахим, цаасан хэлбэрээр, төрийн цахим үйлчилгээний хэлтэс /ХУР систем/ төрийн байгууллага, иргэдэд цахим үйлчилгээний талаарх мэдээллийг хүргэн ажилласан байна.

Төрийн байгууллагын үйлчилгээний талаарх мэдээллийг /хүний нөөцийн сонгон шалгаруулалт, сул орон тоо, худалдан авах ажиллагаа зэрэг/ ил тод, нээлттэй хүргэх зорилгоор www.shilen.gov.mn цахим хуудаст төрийн захиргааны агентлаг, хэлтсүүдийн мэдээллийг байршуулж эхэлсэн байна.

Аудитаар 95 иргэд оролцсон “Дорнод аймгийн Төрийн байгууллагуудын үйлчилгээ ил тод, нээлттэй байна уу?” гэсэн санал асуулгын дүнг нэгтгэн авч үзэхэд дараах байдалтай байна.

Дүрслэл 9. “Санал асуулгын дүн”



Санал асуулгад оролцогчдын 63 хувь нь төрийн байгууллагын үйлчилгээний ил тод байдалд сэтгэл хангалуун байдгаа илэрхийлсэн бол, 37 хувь төрийн байгууллагын үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд анхаарах шаардлагатай болсныг харуулж байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэгт шинжилгээ хийхэд төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд, олон нийтэд үндсэн ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хүргэж сурталчлах ажлыг Засаг даргын дэргэдэх 1 байгууллага огт хэрэгжүүлээгүй байсан нь цаашид анхаарах асуудал болж байсан.

Дүгнэлт: Төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагууд үйл ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудас, фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлж байгаа боловч, санал асуулгад оролцогчдын 63 хувь нь ил тод, мэдээлэх үүргээ биелүүлж байна гэж үзсэн байна. Харин аймгийн ИТХ, Засаг даргын нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг төрийн албан ёсны эрх зүйн мэдээллийн системд /www.legalinfo.mn/ байршуулаагүй байна.

1.2.3. Төрийн үйлчилгээ үзүүлэхэд нөөцийн хуваарилалт жигд хүртээмжтэй байдлаар хийгдэхгүй байна.

Төрийн байгууллагууд 2024 оны 9 дүгээр сарын байдлаар төрийн захиргааны салбарт 120, НӨУБ-д 13, эрүүл мэндийн салбарт 49, боловсролын салбарт 120, соёлын салбарт 18, ТӨҮГ болон ОНӨААТҮГ-т 47 орон тоо сул байна.

Төрийн захиргаа, төрийн үйлчилгээний зарим байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог асуудал эрхэлсэн байгууллагаас тогтоож, хэрэгжүүлж ажиллахыг даалгасан байдаг. Тухайлбал:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 А-1/1819 тоот албан бичгээр Орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тоог 12 байхаар тогтоож, шаардлагатай төсөв хөрөнгийг 2024 оны орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт зөвлөсөн байна. Аймгийн Засаг даргын 2024 оны А/183 дугаар захирамжаар Орон нутгийн өмчийн газрын орон тоог 7 байхаар тогтоожээ.

Орон нутгийн өмчийн бүртгэл, эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, удирдлага, хяналт, шалгалт, мэдээллийн системийг бүрдүүлэх хянах чиг үүргийг тус газрын одоогийн бүтэц, орон тоогоор хэрэгжүүлэхэд хязгаарлагдмал хүний нөөцтэй байгаа тул цаашид шийдвэрлэх асуудал болж байна.

2. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2022 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Соёлын ордон, соёлын төв”-ийн бүтэц, орон тооны жишиг норматив /MNS6981:2002/-ыг баталж, тус стандартаар сумдын соёлын төвийн орон тоог 16.5 байхаар стандартчилсан байна. Одоогийн түвшинд сумын Соёлын төвүүдийн орон тоо 7-11 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байгаа нь нормативд хүрэхгүй байна. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сүүлийн 5 жилд сумдад шинээр соёлын төвүүдийг барьж байгуулсантай холбогдуулан барилга, байгууламжийн хүчин чадлыг бүрэн ашиглах, иргэдэд төрийн үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэхэд хүний нөөцийг нэмэгдүүлэх шаардлага үүссэн байна.

3. Боловсролын салбарт 2024 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 120 орон тоо сул байгаа нь орон нутагт мэргэжилтэй хүний нөөц дутмаг байгааг харуулж байна. Нөгөө талаас сумын ЕБС, төвийн ЕБС-иудын бүтэц, орон тоо ялгаатай байгаа нь асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас багшлах хүчний орон тооны асуудлыг норм, стандартчилаагүй байгаатай холбон тайлбарлаж болох юм.

Дүгнэлт: Дээрх байдлаас харахад хүний нөөцийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалж тухайн сул орон тооны албан тушаалтны чиг үүргийг бусад төрийн албан

хаагчдад давхар хариуцуулснаас ажлын ачаалал үүсгэх, төрийн үйлчилгээ жигд хүртээмжтэй хүрэхгүй байх эрсдэлийг үүсгэсээр байна. Цаашид хүний нөөцийг жигд хүртээмжтэй хуваарилахад төрийн байгууллагуудын хүний нөөцийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны жишиг нормативыг баталж мөрдүүлэх шаардлага үүссэн байна.

1.3. Төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

1.3.1. Эрх бүхий байгууллагаас төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, албан тушаалын давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын 6² дугаар зүйлд заасны дагуу аймгийн Засаг даргын дэргэд байгуулсан чиг үүргийн санал боловсруулах үүрэг бүхий техникийн ажлын хэсгийг байгуулаагүй байна. Мөн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь 2013-2023 онд төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, албан тушаалын давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ авч хяналт хийгээгүй байна.

Аудитаар албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, боловсролын тусгай шаардлага хангахгүй, мэргэжлийн индекс таарахгүй байгаа 13 байгууллагын 24 албан хаагчид зөрчил илэрсэн байна. Эдгээр зөрчлүүд нь дийлэнх нь төрийн үйлчилгээний албан тушаал буюу боловсрол, соёлын салбарт илүү байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 4. “Аудитаар илэрсэн зөрчил, байгууллагаар”

№	Байгууллагын нэр	Алдаа зөрчил
1	Сэргэлэн сумын Соёлын төв	- Албан тушаалын тодорхойлолтод “Бакалавраас дээш боловсролтой, бүжгийн багш мэргэжилтэй” гэж заасан боловч бүжгийн сургалт төгссөн албан хаагч ажиллаж байна. /Бүжигчин/ - Албан тушаалын тодорхойлолтод “Бакалавраас дээш боловсролтой, хөгжмийн багш мэргэжилтэй” гэж заасан боловч хөгжмийн сургалт төгссөн албан хаагч ажиллаж байна. /Хөгжмийн багш/
2	Цагаан-Овоо сумын цэцэрлэг	- Албан тушаалын тодорхойлолтод “Мэргэжил-СӨБ-ын багшийн туслах” гэж заасан боловч багшийн туслах мэргэжлээр суралцаагүй байна. /Багшийн туслах/ - Албан тушаалын тодорхойлолтод “Мэргэжлээрээ дээд сургууль төгссөн болон бакалавр, түүнээс дээш боловсролтой байх” гэж заасан боловч бакалаврын боловсрол эзэмшээгүй байна. /Нярав/
3	Баян-Уул сумын Соёлын төв	Албан тушаалын тодорхойлолтод “Хөгжмийн багш, хөгжимчин мэргэжлээр бакалаврын зэрэгтэй байна.” гэж заасан боловч бакалаврын боловсролгүй, хөгжмийн багш мэргэжлийн сертификаттай байна. /Хөгжмийн багш/
4	Баян-Уул сумын цэцэрлэг	Албан тушаалын тодорхойлолтод “Боловсрол мэргэжлээрээ дээд сургууль төгссөн болон түүнээс дээш боловсролтой байх” гэж заасан боловч бакалаврын боловсрол эзэмшээгүй байна. /Нярав/
5	Цагаан-Овоо сумын ЗДТГ	Албан тушаалын тодорхойлолтын мэргэжил, боловсролын тусгай шаардлага хэсэгт “ХАА, Хүрээлэн буй орчин, Жимс жимсгэнэ, Ногооны аж ахуй” гэж заасан боловч Агроном /D620800/ мэргэжлийн индекс таарахгүй байна. / МААҮТҮБХ-ын мэргэжилтэн/
6	Баяндун сумын Соёлын төв	- АТТ-д “Бакалавр болон түүнээс дээш боловсролтой байх” гэж заасан боловч бүрэн дунд боловсролтой албан хаагч байна. /Номын санч/ - АТТ-д “Бакалавр болон түүнээс дээш боловсролтой байх” гэж заасан боловч бүрэн дунд боловсролтой албан хаагч байна. /Хөгжмийн багш/
7	Баяндун сумын ЕБС	Биологийн багшийн ажлын байранд хүнсний технологич мэргэжилтэй, технологийн багшийн ажлын байранд дипломын боловсролтой хүн ажиллаж байна.

² “Чиг үүргийн шинжилгээ хийх, дахин хуваарилах санал боловсруулах үүрэг бүхий техникийн ажлын хэсгийг (цаашид “ажлын хэсэг” гэх) холбогдох төрийн захиргааны төв байгууллага, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд байгуулна.”

8	Дашбалбар сумын ЗДТГ	- АТТ-д “Мэргэжил, мэргэжлийн индекс ХАА /081101-03/, Жимс ногооны аж ахуй /0812/, Хүрээлэн буй орчин /052/” гэж заасан байхад мэргэжлийн индекс таарахгүй байна. /Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн – Мэргэжил: Байгаль орчны хяналт үнэлгээ/ - АТТ-д “Бакалавр болон түүнээс дээш боловсролтой” гэж заасан боловч бүрэн дунд боловсролтой байна. /Нярав/
9	Дашбалбар сумын ЕБС	- Химийн багшийн ажлын байранд Байгаль хамгаалагч, экологи мэргэжилтэй хүн ажиллаж байна.
10	Дашбалбар сумын цэцэрлэг	- АТТ-д “Бакалавр түүнээс дээш” гэж заасан боловч бүрэн дунд боловсролтой хүн ажиллаж байна. /Нярав/
11	БОАЖГ	- АТТ-д заасан мэргэжил, мэргэжлийн индекс таарахгүй 8 албан хаагчид байна.
12	Татварын газар	- АТТ-д заасан мэргэжил, мэргэжлийн индекс таарахгүй 1 удирдах албан тушаалтан байна.
13	ИТХ	- АТТ-д заасан мэргэжил, мэргэжлийн индекс таарахгүй 1 удирдах албан тушаалтан байна.

Эх сурвалж: Аудитын асуудлын бүртгэл

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн ажил чиг, үүргийг шинэчлэн батлах тухай 2016 оны А/09 дугаар тушаалын дагуу зөвхөн Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн чиг үүргийг шинэчлэн баталсан байна.

Харин Мэргэжлийн индекс (мэргэжил боловсрол) таарахгүй иргэнийг тусгай шалгалтад бүртгэж, тогтоол гаргасан байгаа нь Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.10 дахь “Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.” гэж заасантай нийцэхгүй байгаа тул ТАЗСЗ-д албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 дугаар тогтоолыг үндэслэн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/164 дүгээр захирамж гарган Авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагааны хүрээнд хяналт шалгалтын ажлыг хийсэн байна.

“Шүүр” ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд Дорнод аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага, агентлаг, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын нийт 130 нэгжийн 4423 албан хаагчид хамрагдаж, нийт 78 байгууллагын 159 албан хаагчтай холбоотой 180 зөрчил илэрсэн ба (138 албан хаагчтай холбоотой 159 зөрчил, шалгалтын хугацаанд арилгуулсан 21 албан хаагчтай холбоотой 21 зөрчил) 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 24.5 хувь буюу 39 албан хаагч “Шүүр” ажиллагааны үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн, 41.5 хувь буюу 66 албан хаагчийн зөрчил арилсан байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6.2 дахь “хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд Төрийн албаны зөвлөлөөс баталсан аргачлал, удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” гэж заасантай нийцэхгүй байна.

Дүгнэлт: Төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, албан тушаалын давхардал, хийдлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна. Аудитаар албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, боловсролын тусгай шаардлага хангахгүй, мэргэжлийн индекс таарахгүй байгаа зөрчил 12 байгууллагын 16 албан хаагчид илэрсэн байна.

1.3.2. Орон нутгийн хэмжээнд Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаагаар хангах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1³ дэх зүйлд заасны дагуу байгууллагууд батлагдсан дотоод журмын хүрээнд тусгасан нийгмийн баталгааг ханган ажиллаж байна.

Дорнод аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтын хүрээнд ИТХ-ын 2017 оны 06 дугаар хуралдааны 01 дүгээр “Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих” хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулсан байна.

Үүний дагуу 2020-2023 онд төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх нөөц боломжид тулгуурлан үдийн хоол, унааны хөнгөлөлт, гар утасны төлбөр, сурах болон ар гэрийн гачигдалд цалинтай чөлөө олгох, байгууллагын дотоод журмын дагуу тусламж үзүүлэх, орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр их, дээд сургуульд суралцаж, төгссөн(33 шинээр ажиллаж буй албан хаагч)⁴, малжуулах төсөлд хамруулах(132 албан хаагч), хүнсний ногоо тарих(349 албан хаагч), орон сууцны дэд хөтөлбөрт(77 албан хаагч) хамруулах зэрэг асуудалд байгууллагын онцлог, төсөвт уялдуулан дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 5. “Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрт зарцуулсан төсөв⁵ (сая төгрөг)”

Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Зарцуулсан төсөв	20.0	20.0	30.0	30.0	35.0

Эх сурвалж: Дорнод аймаг дахь салбар зөвлөлийн тайлан 2020-2023 он

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5⁶ дахь зүйлд заасантай нийцүүлэн тус хөтөлбөрийн 4.3.8 дахь зүйлд “Төрийн албан хаагчийг орон сууцны нөхцөлөө сайжруулах, хувийн хашаа байшин барих, орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлнэ” гэсэн заалтын дагуу сум бүр орон нутгийн онцлогт тохируулан төрийн албан хаагчдыг орон сууцжуулах нөхцөл боломжийг сайжруулах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2018-2023 оны байдлаар нийт 7 суманд 77 айлын орон сууцыг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэн ашиглалтад оруулан албан хаагчдын амьдрах орчин, ажиллах нөхцөлийг сайжруулсан байна.

Сумдыг орон сууцжуулсан нь төрийн албаны сул орон тоог нөхөх, орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэжлийн албан хаагчид ажиллуулах боломжийг олгох, цаашлаад тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж байна.

Мөн 2022-2023 оны байдлаар “Дорнодын багш”, “Соёл урлагийн шилдэг ажилтан”, “Би сувилагч” зэрэг төслүүдийг хэрэгжүүлэн 16 төрийн албан хаагчид 320.0 сая төгрөгийн байрны урьдчилгаа олгон дэмжлэг үзүүлсэн байна.

Аудитаар илэрсэн зөрчилд Баяндун сумын ЕБС-д сахилгын шийтгэлтэй албан хаагчид 389,400.0 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. Мөн Баян-Уул сумын ЗДТГ-ын харуулаас 180,000.0 төгрөгийн, аймгийн БОАЖГ-ын 2

³ “Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ.”

⁴ Суралцан төгссөн оюутнуудыг мэргэжлээр ангилбал, хүний их эмч-7, шүдний эмч-2, малын их эмч-5, агрономич-1, багш-16, сувилагч-2 тус тус байна.

⁵ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, зардлыг аймгийн Засаг даргын 2018 оны А/301, 2019 оны А/45, 2020 оны А/168, 2021 оны А/34 дугаар захирамжаар тус тус баталсан байна.

⁶ “орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх;”

мэргэжилтнээс 968,000.0 төгрөгийн сахилгын шийтгэл хүлээлгэсэн суутгал тус тус суутгаж аваагүй байгаа нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчдын мөнгөн урамшуулах олгох журам”-ын 2 дахь зүйлийн 2.7 дахь “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.” гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.


Түүнчлэн Сэргэлэн сумын цэцэрлэгт арга зүйчид 2022 оны 01 дүгээр сараас архив, бичиг хэрэг хавсран гүйцэтгэсэн нэмэгдэл цалингийн 40 хувиар тооцож 3,140,408.0 төгрөгийг тушаал шийдвэргүй олгосон болон Баян-Уул сумын ЗДТГ-ын Нийгмийн бодлогын мэргэжилтэн 2023 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлсэн хуудас байхгүй, 12 дугаар сарын 01-ний өдрөөс ажилдаа орсон боловч урамшууллыг 40 хувиар буюу 440,000.0 төгрөг авсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэж заасантай нийцэхгүй байна.

Дүгнэлт: Орон нутгийн хэмжээнд Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаагаар хангах нөхцөлийг бүрдүүлэн 2017 оноос хойш тогтвортой ажиллаж байна.

1.3.3. Төрийн байгууллагууд гарсан сул орон тоог хууль болон холбогдох журмын дагуу олон нийтэд ил тод мэдээлж байна.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1⁷, 27.2⁸-д заасны дагуу Төрийн байгууллагууд сул орон тоо гарсан үед өөрийн байгууллагын сайт, цахим сүлжээнд байршуулах эсвэл төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн цахим сүлжээгээр олон нийтэд мэдээлж байна.

Дүрслэл 10. “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн сул орон тоог нөхөн бүрдүүлсэн байдал”



Эх сурвалж: Дорнод аймаг дахь салбар зөвлөлийн тайлан 2020-2023 он

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2020-2023 оны байдлаар давхардсан тоогоор нийт 813 сул орон тоог зарлаж Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор батлагдсан журмын дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулан 18.8-39.7 хүртэл хувиар албан тушаалын сул орон тоог нөхөн томилсон байна. Мөн аймгийн төрийн албан хаагчийн нөөцөд сүүлийн 4 жилийн хугацаанд 353 хүн төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцэн бүртгэгдсэн байна.

⁷ Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө:

⁸ Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.

Аймгийн ЗДТГ-т Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоонд тусгай шалгалтгүйгээр 2021-2022 онуудад Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст “Уул уурхай, хүнд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн”, “Эдийн засаг, бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн”, “Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн”, Хууль, эрх зүйн хэлтэст “Эрх зүйн сургалт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн” гэсэн 4 албан хаагчийг түр томилох тухай тушаал гаргасан байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.⁹ -д заасантай нийцэхгүй байна.

Мөн Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.2-т “Дээд боловсролтой байх,” гэж заасныг зөрчсөн 1 тохиолдол гарсан байна.

Аймгийн ОНӨГ-ын дарга нь “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа нь хууль, журамд нийцэхгүй байна. Тухайлбал: Хөдөлмөрийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно.”, даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1-д “ОНӨААТҮГ-уудад хуулийн хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллаж буйд үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийж ажиллах” гэж тус тус заасан. Хяналт тавих чиг үүрэгтэй байгууллагад давхар ажил гүйцэтгэж байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 28.1 дэх заалттай нийцэхгүй байгаа тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Дүгнэлт: Төрийн байгууллагууд гарсан сул орон тоог хууль тогтоомжийн дагуу 2020-2023 оны байдлаар давхардсан тоогоор нийт 813 сул орон тоог зарлаж, олон нийтэд ил тод мэдээлж, нөхөн томилсон байна.

1.3.4. Төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирлын тоог бууруулах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд 2014-2023 оны байдлаар Шүүхийн шийдвэрээр 7 сумын 18 байгууллагын 23 төрийн албан хаагчийн зардалд нийт 149.3 сая төгрөгийг хариуцагч байгууллагаас гаргуулж барагдуулахаар шийдвэрлэжээ.

Хүснэгт 6. “Төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд хохирол учруулсан тоо мэдээ, 2014-2024 он”

№	Сумын нэр	Хамрах он							Нийт мөнгөн дүн
		2015	2016	2017	2018	2020	2021	2022	
1	Хэрлэн	2	3	2	3	1	1	2	87,072,388.0
2	Гурванзагал				1			1	22,346,645.0
3	Баянтүмэн		2	1					27,591,795.0
4	Чойбалсан							1	6,671,898.0
5	Матад				1				
6	Халхгол	1	1						5,582,516.0
7	Баян-Уул				1				
Нийт дүн		3	6	3	6	1	1	4	149,265,242.0

Эх сурвалж: Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газар, 2024 оны 11 сар

9 Ерөнхий шалгалтыг төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй, энэ хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан иргэн, төрийн үйлчилгээний болон улс төрийн албан хаагчаас, тусгай шалгалтыг энэ хуулийн 18.1-д заасан төрийн захиргааны албан тушаалын ангилал хооронд шилжих тохиолдолд болон энэ хуулийн 27.1.3, 33.8-д заасан нөөцөд байгаа иргэдээс тус тус авна.

Мөн 2014 оноос хойших төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд учруулсан хохирлын нийт дүнд 24 хувийг буюу ойролцоогоор ¼-г зөвхөн 2022 онд учруулсан хохирол эзэлж байна.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1¹⁰ дэх, 50.2¹¹ дахь заалтын хүрээнд аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд төрд учруулсан хохирлын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.6.2 дахь "Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй байна.

Дүгнэлт: Сүүлийн 10 жилийн хугацаанд төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд учирсан хохирлын талаар ТАЗСЗ-өөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна. Иймд төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирлын тоог бууруулах арга хэмжээ авах шаардлагатай байна.

1.3.5. Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлсэн ч мэдээллийг үр дүнтэй боловсруулах, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт хийх нөхцөл бүрдээгүй байна.

Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим систем 2022 онд шинэчилсэнтэй холбогдуулан тус (<https://hrm.csc.gov.mn/>) системд нутгийн захиргаа болон төрийн захиргааны нийт 158¹² байгууллагын төрийн албан хаагчийн нэгдсэн мэдээллийг шинэчлэн баяжуулж ажилласан байна. Энэ нь төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, шилжилт хөдөлгөөн, тоо бүртгэл, нэгдсэн судалгаа, статистик мэдээллийг шаардлагатай хугацаанд гаргах боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой байна.

Гэвч Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс тус системээр дамжуулан нийт мэдээллийг боловсруулан шаардлагатай статистик гаргах (тайланд ашиглах), мэдээллийн үнэн зөв байдалд хяналт хийх нөхцөл бүрдээгүй байна. Тухайлбал, Цалингийн сахилгын шийтгэл холбогдоогүй, цалингийн нэмэгдлүүдийг нэмээд оруулахад шууд бодогдохоор байна. Нэмэгдэл олгох эрх бүхий албан тушаалтан хянаж батлах тохиргоо байхгүй байна. Мөн системд индекс таарахгүй бол бүртгэхгүй байх, дараагийн үе шат руу шилждэггүй байхаар программчлах, дээд боловсролгүй иргэнийг ерөнхий шалгалтад орохоор бүртгүүлэхэд шууд бүртгэлд авч байгаа зэргийг системд сайжруулалт хийх шаардлагатай байна.

Дүгнэлт: Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлсэн ч Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс тус системээр дамжуулан нийт мэдээллийг боловсруулан шаардлагатай статистик гаргах (тайланд ашиглах), мэдээллийн үнэн зөв байдалд хяналт хийх нөхцөл бүрдээгүй байна.

¹⁰ "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ."

¹¹ "Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана."

¹² Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тайлан 2020-2023 он

БҮЛЭГ 2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.1. Иргэндээ үйлчилдэг мэргэшсэн, чадварлаг ил тод төрийн алба төлөвшөөгүй байна.

2.1.1 Төрийн албан хаагчдыг орон зайнаас үл хамааруулан сургаж байна.

Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан мэргэшүүлэх багц сургалт болон 29 дүгээр зүйлд заасан албан тушаалын ажлын байрны сургалтад төрийн албан хаагчдыг хамруулахаар заасан.

Төрийн албаны зөвлөлийн аймаг дахь Салбар зөвлөл нь 2021-2023 онуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө хуульд заасан мэргэшүүлэх багц сургалтад төрийн албан хаагчдыг хамруулахад хяналт тавьж, төрийн байгууллагуудаас төрийн албан хаагчдын богино, дунд хугацааны сургалт, мэргэшүүлэх багц сургалт, бусад богино хугацааны сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгааг авч нэгтгэн ажилласан байна. Үүнд:

Хүснэгт 7. “Төрийн албан хаагчдыг сургалтад хамруулсан байдлын судалгааг 2021-2023 оноор хүснэгтээр үзүүлбэл:”

	Он	Сургалтын нэр төрөл							
		Төрийн албанд анх томилогдсоны дараах	Мэргэшүүлэх дунд хугацааны сургалт	Мэргэшүүлэх дунд хугацааны давтан	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт	Засгийн газрын зорилтот сургалт	ТАЗ-ийн арга зүйн сургалт	УА-ын богино хугацааны сургалт	Мэргэжлийн бусад байгууллагын сургалт
Хамрагдсан албан хаагчийн тоо	2021	15	7	15	3	1096	1,159	162	588
	2022	62	18	67	18	118	4,842	46	2416
	2023	11	26	5	4	264	2,018	131	665
Нийт		88	41	87	25	1,478	8,019	339	3,669

Эх сурвалж: ТАЗ-ийн салбар зөвлөлийн 2021-2023 онуудын үйл ажиллагааны тайлан, судалгааны нэгтгэл

Дээрх судалгаанаас үзэхэд төрийн байгууллагаас 2021-2023 онд төрийн албанд анх томилогдсоны дараах богино хугацааны сургалтад 88, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 41, төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 87, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багцад 25 албан хаагчдыг тус тус хамруулсан бол бусад богино хугацааны сургалтад 13,505 албан хаагчдыг тус тус хамруулсан байна.

Мөн аймгийн хэмжээнд төрийн байгууллагууд тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө дотоод сургалтын зорилт арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал, байгууллагууд албан хаагчдынхаа мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ажлын байран дээр мэргэжлийн болон мэргэжлийн бус бусад дотоод сургалтад хамруулж байна.

Дүгнэлт: Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хуульд заасан сургалтад хамруулсан байна.

2.1.2. Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль, журамд заасны дагуу шилжүүлэн ажиллуулсан байна.

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлд төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулахаар заасан байна.

Аймгийн хэмжээнд төрийн байгууллагууд төрийн жинхэнэ албан хаагчийг Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулсан байна.

Тухайлбал,

- Аймгийн ЗДТГ-аас 2022 онд 1, 2023 онд 1, 2024 онд 2 албан хаагчийг,
- Аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2023 онд 1, 2024 онд 1 албан хаагчийг,
- Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2022 онд 1, 2024 онд 1 албан хаагчийг,
- Цагаан-Овоо сумын ЗДТГ нь 2020 онд 2 ажилтныг,
- Цагаа-Овоо сумын Соёлын төв нь 2022 онд 2 ажилтныг,
- Баян-Уул сумын ЗДТГ нь 2023, 2024 онд 2 ажилтныг тус тус шилжүүлэн ажиллуулсан байна.

Өөр байгууллагаас шилжүүлэн авч ажиллуулсан дараах тохиолдол байна. Үүнд:

- Баян-Уул сумын ЗДТГ нь 2017 онд 1 ажилтныг шилжүүлэн авч, 2023, 2024 онд тус тус 1 ажилтныг,
- Дашбалбар сумын ЗДТГ нь 2023 онд 1 ажилтныг,
- Сэргэлэн сумын ЗДТГ нь 2021 онд 1 ажилтныг тус тус шилжүүлэн авч ажиллуулсан байна.

Аймгийн хэмжээнд төрийн байгууллагууд өөрийн албан хаагчийн өөр албан тушаалд шилжин ажиллах хүсэлтийг харгалзан шилжүүлсэн ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдолд түүнийг нөхөх захиалгыг ТАЗ-ийн салбар зөвлөлд хүргүүлсний дагуу салбар зөвлөл нь 2023 онд өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай зарыг Төрийн албаны зөвлөлийн csc.gov.mn цахим хаяг, аймгийн ЗДТГ-ын dornod.gov.mn цахим хаягт мэдээлж, 31 албан хаагчийг өөр тушаалд шилжүүлэн ажиллуулж байна.

Дүгнэлт: Төрийн жинхэнэ албан хаагчийг Төрийн албаны тухай хууль, түүнтэй холбогдох журамд заасны дагуу шилжүүлэн ажиллуулсан байна.

2.1.3. Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай төрийн албан хаагчийг бэлтгээгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 06 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжих хугацаа 2021 онд дуусаж, тус хөтөлбөрт төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор холбогдох сургалтад хамруулах талаар тусгасан ч мэдээллийн технологийн чиг үүргийг хариуцан гүйцэтгэх хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх талаар тухайлсан зорилт арга хэмжээг тусгаагүй байна.

Энэ хөтөлбөрийн хүрээнд жил бүр орон нутгийн төсөвт үйл ажиллагааны төсөв тусган хэрэгжүүлдэг боловч төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай мэдээллийн технологийн чиглэлийн албан хаагчдыг бэлтгэх тусгайлсан мэргэшүүлэх сургалт зохион байгуулагдаагүй байна.

Иймд төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай хүний нөөцийг бэлтгэхэд тодорхой үр дүнтэй сургалт зохион байгуулах шаардлагатай байна.

Дүгнэлт: Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай мэдээллийн технологийн чиг үүргийг хариуцан гүйцэтгэх хүний нөөцийг бүрдүүлээгүй байна.

2.1.4. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт төрийн байгууллагуудад хангагдаагүй байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай 11 дүгээр зүйлийн 11.3.1-д “жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөгөө, хөтөлбөрийн үндсэн дээр хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар ажилтнуудад мэдээлж байх,” гэж заасныг төрийн зарим байгууллагууд хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал, аймгийн ИТХ, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Орон нутгийн өмчийн газар гэх мэт.

Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8-д “... нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендэрийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх,” гэж заасны дагуу аймаг, сумын Засаг дарга нар 2023 оны жилийн тайлан, мэдээг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн эсэхэд аудитын горим сорил хэрэгжүүлэхэд Баяндун сумаас бусад сум загвар маягтын дагуу тайланг гаргаж хүргүүлээгүй байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг үндэслэн аймгийн ИТХ-ын 2018 оны 21 дүгээр тогтоолоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийг 2018-2021 он хүртэл хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна. Энэ хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтэд төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдыг хүйсээр ангилсан статистик үзүүлэлт байхгүй байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/84 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтаар жендэрийн салбар хорооны бүрэлдэхүүнийг, түүний ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсан байна.

Аудитын явцад нутгийн захиргааны байгууллага буюу аймаг, сумын Засаг даргын Тамгын газарт ажиллаж байгаа төрийн албан хаагчийн 2024 оны 11 дүгээр сарын байдлаарх хүйсийн харьцааны тоог аймаг, сумын ЗДТГ-ын холбогдох албан хаагчдаас авч хүйсийн тэнцвэрт байдлын харьцааг гаргасан нь дараах байдалтай байна.

Хүснэгт 8. “Аймаг, сумын ЗДТГ-ын албан хаагчдын хүйсийн харьцаа”

№	Сумын нэр	Нийт төрийн албан хаагчийн тоо	Хүйс		Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Эрэгтэйчүүдийн эзлэх хувь
			Эмэгтэй	Эрэгтэй		
1	Баяндун	21	7	14	33.3	66.7
2	Баянтүмэн	26	12	14	46.2	53.8
3	Баян-Уул	31	15	16	48.4	51.6
4	Булган	29	9	20	31.0	69.0
5	Гурванзагал	21	7	14	33.3	66.7
6	Дашбалбар	21	8	13	38.1	61.9
7	Матад	27	9	18	33.3	66.7
8	Сэргэлэн	26	13	13	50.0	50.0
9	Халхгол	21	15	6	71.4	28.6
10	Хөлөнбуйр	21	9	12	42.9	57.1
11	Хэрлэн	77	57	20	74.0	26.0
12	Цагаан-Овоо	25	14	11	56.0	44.0
13	Чойбалсан	23	11	12	47.8	52.2
14	Чулуунхороот	25	15	10	60.0	40.0
15	Аймаг	95	57	38	60.0	40.0
	Нийт	489	258	231	52.8	47.2

Эх сурвалж: Аудитын хүрээнд авсан нэгдсэн судалгаа

Дээрх тоон мэдээллээс үзэхэд аймгийн ЗДТГ, Дашбалбар, Сэргэлэн, Чойбалсан, Чулуунхороот сумын ЗДТГ-аас бусад сумын ЗДТГ хүйсийн тэнцвэрт байдлыг хангаагүй гэж үзэхээр байна.

Аймгийн хэмжээнд төрийн байгууллага, түүнд хамаарах төрийн албан хаагчийн 2023 оны жилийн эцсийн байдлаарх хүйсийн харьцааны тоон мэдээллийг дараах хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 9. “Хүйсийн харьцааны тоон мэдээлэл”

№	Сумын нэр	Байгууллагын тоо	Нийт төрийн албан хаагчийн тоо	Хүйс		Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Эрэгтэйчүүдийн эзлэх хувь
				Эмэгтэй	Эрэгтэй		
1	Чойбалсан	45	1,866	1,280	586	68.6	31.4
2	Баяндун	6	195	132	63	67.7	32.3
3	Баянтүмэн	6	128	85	43	66.4	33.6
4	Баян-Уул	6	229	175	54	76.4	23.6
5	Булган	6	125	74	51	59.2	40.8
6	Гурванзагал	6	134	80	54	59.7	40.3
7	Дашбалбар	6	162	130	32	80.2	19.8
8	Матад	6	166	114	52	68.7	31.3
9	Сэргэлэн	6	126	85	41	67.5	32.5
10	Халхгол	9	200	147	53	73.5	26.5
11	Хөлөнбуйр	6	133	89	44	66.9	33.1
12	Хэрлэн	28	1,550	1,224	326	79	21
13	Цагаан-Овоо	6	149	107	42	71.8	28.2
14	Чулуунхороот	6	126	102	24	81	19
	Нийт	148	5,289	3,824	1,465	72.3	27.7

Эх сурвалж: Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн 2023 оны тайлан

Дээрх тоон мэдээлэлд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын албан хаагчдын тоон мэдээлэл ороогүй байна.

Төрийн албаны зөвлөлөөс гаргасан Дорнод аймаг дахь төрийн байгууллага, түүнд хамаарах тоон мэдээллийн нийт дүнгээс үзэхэд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан байхад 40:60 гэсэн харьцаа бүхий хүйсийн тэнцвэрт байдал хангагдаагүй байна.

Иймд дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд аймаг, сумын хэмжээнд төрийн байгууллага тус бүрийн нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх, мөн төрийн байгууллагууд хүйсээр ангилсан тоон мэдээлэл гаргах шаардлагатай байна.

Дүгнэлт: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.2. Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран авах нөхцөл боломж бүрдсэн боловч үйлчилгээ жигд, хүртээмжтэй хүрч чадахгүй байна.

2.2.1. Иргэдэд хүрэх төрийн үйлчилгээ цахимжиж шат дамжлага багассан байна.

Засгийн газрын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 6 дугаар зүйлийн 6.1, “Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 6 дугаар зүйлийн 6.1, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтын дагуу иргэд цахим шилжилт бүхий “Дижитал Дорнод” төслийг хэрэгжүүлэх тухай ИТХ-ын 2022 оны 13/12 дугаар тогтоол баталсан боловч хэрэгжүүлэх төсвийг орон нутгийн төсөвт тусгах боломжгүй улмаас хэрэгжүүлээгүй байна.

Харин 2022 онд төрийн үйлчилгээний нэгдсэн систем(www.operator.e-mongolia.mn) -ээр 11 байгууллагын 278 үйлчилгээг 1601 иргэнд, 2023 онд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас улсын хэмжээнд “Хурдан” төрийн үйлчилгээний цахим системээс 43 байгууллагын 478 үйлчилгээ, 98 лавлагаа, тодорхойлолтыг авах боломжтой болсонтой холбоотойгоор орон нутагт 39 байгууллагын 461 үйлчилгээ, 94 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг 3952 иргэнд тус тус олгож ажилласан байна.¹³ Өмнөх оноос цахимаар авах үйлчилгээ, лавлагаа 107 хувиар, үйлчилгээнд хамрагдсан иргэд 147 хувиар тус тус өссөн байна.

Дүгнэлт: Иргэдэд хүрэх төрийн үйлчилгээ цахимжиж шат дамжлага багасаж, цахим үйлчилгээ, лавлагааны хэмжээ нэмэгдсэн байна.

2.2.2. Орон нутагт төрийн үйлчилгээ жигд, хүртээмжтэй хүрч байгааг үнэлэх боломжгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1¹⁴ дэх хэсэг болон Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрмийн 2.1.3¹⁵-т заасны дагуу орон нутагт төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд судалгаа хийн үнэлэлт өгч, дүгнэлт гаргаж ажилладаггүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6.2 дахь “Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих” гэж заасантай нийцэхгүй байна.

Дүгнэлт: Орон нутагт төрийн үйлчилгээ жигд, хүртээмжтэй хүрч байгааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй тул үнэлэх боломжгүй байна.

2.3. Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд хяналт тавих тогтолцоо бүрдээгүй байна.

2.3.1. Төрийн байгууллагууд харилцан уялдаа холбоотой ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар төрийн байгууллагууд хоорондоо хүний нөөцийн чиглэлээр эйбл систем, цахим шуудангийн хаяг, вэб сайт, албан бичиг

¹³ Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тайлан 2020-2023 он

¹⁴ “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ.”

¹⁵ “төрийн албаны холбогдох байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд хөндлөнгийн судалгаа хийж, үнэлэлт өгөх, дүгнэлт гаргах;”

болон холбогдох мэдээллийн хэрэгслээр харилцан мэдээлэл солилцож, уялдаа холбоотой ажиллаж байна.

Мөн аймгийн төрийн байгууллагуудаас төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд түүний сонгон шалгаруулалт явуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж хамтран ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академиас хийгдэх сургалтад төрийн байгууллагуудад албан хаагчдаа хамруулах талаар харилцан уялдаатай ажиллаж байна.

Дүгнэлт: Аймгийн төрийн байгууллагууд хүний нөөцийн талаар харилцан уялдаатай ажиллаж байна.

2.3.2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх олон нийтийн хяналтын зөвлөл байхгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1¹⁶-д төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэхээр заасан боловч аймагт олон нийтийн хяналтын зөвлөл байхгүй байна.

Дүгнэлт: Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд хяналт тавих олон нийтийн зөвлөл байхгүй байна.

¹⁶ “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ.”

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн түвшинд төрийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги батлагдан гараагүй, аймаг, сумын ЗДТГ-ын зохион байгуулалтын бүтцийг ЗГ-ын тогтоолд нийцүүлэн боловсруулж, батлаагүй байна. Аймгийн дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан засаглал, хүний нөөцийн бодлого нь улсын хөгжлийн бодлоготой нийцсэн байна.
2. ЗГ-аас тогтоосон бүтэц, орон тооны хязгаар нь ерөнхий байдлаар батлагдсанаас шалтгаалж, ЗДТГ-ын орон тоо харилцан адилгүй батлагдаж, хязгаараас хэтэрсэн байдалтай байна.
3. Хүний нөөцийн бодлогын зорилтын хэрэгжилт нь нэгдмэл, цогц, харилцан уялдаатай, тасралтгүй байх зарчмыг хангахгүй байгаа бөгөөд биелэлтэд ахиц дэвшил гараагүй байна.
4. Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-үнэлгээг хийгээгүй, үр нөлөөг тооцохгүй байгаа нь бодлогын хэрэгжилтэд тавих хяналт сул байгааг харуулж байна.
5. Төрийн байгууллагуудын хүний нөөцийн хүрэлцээнд хийсэн шинжилгээгээр төрийн захиргааны салбарын хүний нөөцийн хүрэлцээ 90.2 хувь, соёлын салбарын хүний нөөцийн хүрэлцээ 92.8 хувь, бусад салбарт 94.4-94.7 хувь хангагджээ.
6. Төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагууд үйл ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудас, фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлж байгаа боловч, санал асуулгад оролцогчдын 63 хувь нь ил тод, мэдээлэх үүргээ биелүүлж байна гэж үзсэн байна. Харин аймгийн ИТХ, Засаг даргын нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг төрийн албан ёсны эрх зүйн мэдээллийн системд /www.legalinfo.mn/ байршуулаагүй байна.
7. Хүний нөөцийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалж тухайн сул орон тооны албан тушаалтны чиг үүргийг бусад төрийн албан хаагчдад давхар хариуцуулснаас ажлын ачаалал үүсгэх, төрийн үйлчилгээ жигд хүртээмжтэй хүрэхгүй байх эрсдэлийг үүсгэсээр байна. Цаашид хүний нөөцийг жигд хүртээмжтэй хуваарилахад төрийн байгууллагуудын хүний нөөцийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны жишиг нормативыг баталж мөрдүүлэх шаардлага үүссэн байна.
8. Төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, албан тушаалын давхардал, хийдлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна. Аудитаар албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, боловсролын тусгай шаардлага хангахгүй, мэргэжлийн индекс таарахгүй байгаа зөрчил 12 байгууллагын 16 албан хаагчид илэрсэн байна.
9. Орон нутгийн хэмжээнд Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаагаар хангах нөхцөлийг бүрдүүлэн 2017 оноос хойш тогтвортой ажиллаж байна.
10. Төрийн байгууллагууд гарсан сул орон тоог хууль тогтоомжийн дагуу 2020-2023 оны байдлаар давхардсан тоогоор нийт 813 сул орон тоог зарлаж, олон нийтэд ил тод мэдээлж, нөхөн томилсон байна.
11. Сүүлийн 10 жилийн хугацаанд төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд учирсан хохирлын талаар ТАЗСЗ-өөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна. Иймд төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирлын тоог бууруулах арга хэмжээ авах шаардлагатай байна.

12. Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлсэн ч Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс тус системээр дамжуулан нийт мэдээллийг боловсруулан шаардлагатай статистик гаргах (тайланд ашиглах), мэдээллийн үнэн зөв байдалд хяналт хийх нөхцөл бүрдээгүй байна.
13. Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хуульд заасан сургалтад хамруулсан байна.
14. Төрийн жинхэнэ албан хаагчийг Төрийн албаны тухай хууль, түүнтэй холбогдох журамд заасны дагуу шилжүүлэн ажиллуулсан байна.
15. Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай мэдээллийн технологийн чиг үүргийг хариуцан гүйцэтгэх хүний нөөцийг бүрдүүлээгүй байна.
16. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.
17. Иргэдэд хүрэх төрийн үйлчилгээ цахимжиж шат дамжлага багасаж, цахим үйлчилгээ, лавлагааны хэмжээ нэмэгдсэн байна.
18. Орон нутагт төрийн үйлчилгээ жигд, хүртээмжтэй хүрч байгааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй тул үнэлэх боломжгүй байна.
19. Аймгийн төрийн байгууллагууд хүний нөөцийн талаар харилцан уялдаатай ажиллаж байна.
20. Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд хяналт тавих олон нийтийн зөвлөл байхгүй байна.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

ОРОН НУТАГТ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, СТРАТЕГИ БАТЛАГДААГҮЙ, ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨТЭЙ ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

Аудитын дүн: Аудитаар нийт 5.1 сая төгрөгийн 25 зөрчил илэрснээс 5.1 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 12 зөвлөмжийг аймгийн ИТХ, Засаг дарга, ТАЗСЗ-ийн дарга нарт, 6 саналыг ҮАГ-аар дамжуулан Монгол улсын Засгийн газар, ТАЗ, Боловсролын яаманд хүргүүллээ.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ	
Санхүүжилтийн гэрээний 9 дүгээр баг Харлын сум, Дорнод аймаг, 21000 Утас: 7059-1041, 7059-3042, Факс: 7059-1681 Цахим хуудас: aad@dnod.gov.mn Цахим хуудас: dnod.gov.mn Аймгийн хэмжээнд зохих байгуулсан Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө хүний нөөцийн гүйцэтгэлийн аудитын тайланттай танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Хүний нөөцийн системийн нэгтгэлийн тайланг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл аймгийн хэмжээнд хянах, шаардлагатай статистик тоон мэдээллийн байгууллага бүрээр харах системийн хөгжүүлэлтийг боловсронгуй болгох. Төрийн байгууллагад шинээр орж байгаа иргэний бүртгэлийг хүний нөөцийн системд оруулахад шүүхийн тогтоолоор нийтийн албанд ажиллах эрх хассан ял шийтгүүлсэн иргэн төрийн аль ч байгууллагаас тухайн албан тушаалтанг системд бүртгэх боломжгүй байхаар системд өөрчлөлт оруулах. Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл олгож байгаа албан тушаалын тодорхойлолтыг мэргэжилтэн /ахлах мэргэжилтэн/ гэсэн тодотголтой зөвшөөрөл олгох, Засгийн газрын тогтоолоор бүтээц орон тоо нэмэгдсэн байхад Төрийн албаны зөвлөлөөс нэмэгдсэн орон тооны албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгохгүй хүлээлт үүсгэж байна. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар "Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг тогтоох тухай" тогтоолоор зөвхөн аймгийн удирдлага, засаг даргын тамгын газрын бүтцийг 6 хэлтэс, цэргийн штаб, архивын тасаг, төрийн үйлчилгээ-мэдээллийн төвтэй байхаар 57 орон тоотой байна гэж баталсан бөгөөд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий үйлчилгээний албан хаагчдын орон тооны хязгаарыг тусгаж өгөөгүй байдаг тул аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 14.2.12-т "эрхлэх асуудлын хүрээнд хамарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох" гэсэн хуульд заасан эрхийн хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газрын бүтцийг шинэчлэн батлахдаа төрийн үйлчилгээний албан хаагчийн орон тоог бүтцэд оруулж баталсан.	
2	
Орон нутгаас санхүүждэг аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагуудын бүтэц орон тоог яам, ерөнхий газраас батлаж байгаа нь Төсвийн хуулийн 14.2.12-т заасан аймгийн Засаг даргын эрх хэмжээнд нөлөөлж байгаа тул хуулийн дагуу чиг үүрэг хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг бий болгох. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" тогтоолын 2 дугаар хавсралтын "Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг"-ийг хасаж тухай албан тушаалын зорилго зорилт, тусгай шаардлагыг батлах зөвшөөрөл олгодог байхаар хавсралтыг өөрчлөх. Албан тушаалын чиг үүргийг төсвийн захирагчтай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж үр дүнг тооцдог байх гэсэн саналуудыг хүргүүлж байна.	
ДАРГА	П.БАТ-ӨЛЗИЙ

Саналд өгсөн тайлбар:

Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймаг дахь салбар зөвлөлөөс 2024.11.20-ны өдрийн 95 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлбарт аудитын шийдвэртэй холбоотой санал зөвлөмж байхгүй тул аудитаар илэрсэн асуудлыг хэвээр үлдээн нэмэлтээр ирүүлсэн саналыг аудитын уламжлах санал хэсэгт тусгахаар шийдвэрлэв.

ҮАГ-ААР ДАМЖУУЛАН ХОЛБОГДОХ ГАЗРУУДАД УЛАМЖЛАХ САНАЛ:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоолоор аймаг, сумын ИТХ-ын ажлын албаны бүтэц, орон тооны хязгаар, 2021 оны 377 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГ-ын бүтэц, орон тооны хязгаар, 2009 оны 13 дугаар тогтоолоор сумын ЗДТГ-ын орон тооны хязгаарыг хүн амын тооноос хамаарч ялгаатай байхаар тус тус баталсан байна. Тогтоолоор зохион байгуулалтын бүтэц, орон тоог ерөнхий байдлаар буюу төрийн улс төр, захиргаа, үйлчилгээний албан хаагчдын тоог дурдаагүй баталснаас шалтгаалж, аймаг, сумдын ЗДТГ-ын орон тоо өөр хоорондоо харилцан адилгүй, хязгаараас хэтэрсэн байдалтай явж байна. Яам, агентлаг, ерөнхий газраас тусгай чиг үүрэг бүхий албан тушаалтныг орон нутагт томилохдоо цалингийн асуудлыг орон нутагт шийдвэрлэхээр томилж, ЗДТГ-ын орон тоонд нэмэгдэж явж байна. Тухайлбал, ШӨХТГ-ын орон нутаг дахь улсын байцаагч, Цэргийн штабын 4 мэргэжилтэн, ТАЗСЗ-ийн нарийн бичгийн дарга гэх мэт албан тушаалтныг холбогдох төв байгууллагаас томилсон байна.

Санал 1. Аймаг, сумдын ЗДТГ-ын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталж, орон тоог зохион байгуулалтын бүтцэд уялдуулан улс төр, төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албан тушаал бүрээр нарийвчилсан байдлаар тогтоох, яам, агентлаг, төв байгууллагаас томилогддог албан хаагчдын цалингийн асуудлыг улсын төсвөөс шийдвэрлэдэг байх талаар Засгийн газарт уламжлах.

2. Аймгийн хэмжээнд боловсролын салбарт 2024 оны 09 дүгээр сарын байдлаар нийт 120 орон тоо сул байгаа нь орон нутагт мэргэжилтэй хүний нөөц дутмаг байгааг харуулж байна. Нөгөө талаас сумын ЕБС, төвийн ЕБС-иудын бүтэц, орон тоо ялгаатай байдлаар зохион байгуулагдаж, аймгийн төв, сумдад багшийн ачаалал харилцан адилгүй байна.

Аудитын явцад албан төрийн зарим байгууллагын албан тушаалын тодорхойлолтын мэргэжил, боловсролын тусгай шаардлага хэсэгт мэргэжлийн ерөнхий нэршил таарч байгаа боловч мэргэжлийн индекс тохирохгүй байх нийтлэг зөрчил илэрч байна.

Санал 2. ЕБС-ийн багшийн орон тооны жишиг нормативыг баталж, мөрдүүлэх, улсын хэмжээний их, дээд сургуулиудын мэргэжлийн индексийг нэг мөр болгож, ойлголтын зөрүүг арилгах арга хэмжээ авах талаар Боловсролын яаманд уламжлах.

3. Хүний нөөцийн олон улсын байгууллагаас 50 ажилтан тутамд 1 хүний нөөцийн ажилтан /мэргэжилтэн/ байхаар зөвлөдөг боловч одоогийн нөхцөл байдлаар Төрийн байгууллагуудын зохион байгуулалтын бүтцэд орон тооны хүний нөөцийн мэргэжилтэн батлагдаагүй.

Санал 3. Хүний нөөцийн бодлогын түвшинд 50-аас дээш албан хаагчтай төрийн байгууллагад батлагдсан хүний нөөцийн мэргэжилтэнтэй байх зохицуулалтыг бий болгож, хэрэгжилтийг хангуулах талаар Засгийн газар, Төрийн албаны зөвлөлд уламжлах.

Санал 4. Хүний нөөцийн системийн нэгтгэлийн тайланг аймгийн хэмжээнд хянах, шаардлагатай статистик тоон мэдээлэл үүсгэх, орон нутагт админ эрхийг нээж өгөх зэргээр ХНУМС-ийн /<https://hrm.csc.gov.mn/> хөгжүүлэлтэд сайжруулалт хийх саналыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх.

Тухайлбал:

- Цалингийн сахилгын шийтгэлийн шийдвэр, цалингийн нэмэгдлүүдийг системд холбох, нэмэгдэл олгох эрх бүхий албан тушаалтан хянаж батлах тохиргоог үүсгэх,
- Тусгай шалгалтад мэргэжлийн индекс таарахгүй бол дараагийн үе шатанд шилжихгүй байхаар программчлах,
- Төрд учруулсан хохиролтой холбоотой төрийн албанд орох эрхгүй иргэнийг системд бүртгэхгүй байхаар тохируулах,
- Дээд боловсролгүй иргэнийг ерөнхий шалгалтад орохоор бүртгүүлэхэд шууд бүртгэлд авч байгааг засах гэх мэт.

Санал 5. Төрийн албаны ерөнхий шалгалтын агуулга, тусгай шалгалтын үр дүнгүй байдалд дүгнэлт хийж, өөрчлөлт оруулах, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргыг /ЗДТГ-ын дарга давхар гүйцэтгэдэг/ бодлогын түвшинд хараат бус, бие даасан байдлаар томилж, чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх, орон тооны албан хаагчаар гүйцэтгүүлдэг байх, ТАЗСЗ нь улсын бүртгэлийн гэрчилгээгүй байх бөгөөд эрх мэдлийг нэмэгдүүлэх үүднээс эрх зүйн чадамжтай болгох асуудлыг шийдвэрлэх саналыг ТАЗ-д уламжлах.

Санал 6. Аймгийн БОАЖГ-ын даргын албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ-өөс баталсан байх тул Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д заасны дагуу тус эрхийг томилох эрх бүхий албан тушаалтанд шилжүүлэх талаар ТАЗ-д уламжлах.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна.

Аймгийн ИТХ-ын дарга Г.Цолмонд

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар аймгийн хэмжээнд нийт төрийн албан хаагчдын нэгдсэн хүний нөөцийн стратеги төлөвлөгөө, бодлого, хөтөлбөрийг баталж, мөрдүүлэн, хэрэгжилтийг хангуулах.
2. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь заалтыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн Засаг дарга Ш.Ёлд

3. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлж, сумын ЗДТГ-ын зохион байгуулалтын бүтцийн талаар санал боловсруулж, ЗГХЭГ-тай зөвшилцөн баталж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах.
4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 А-1/1819 тоот албан бичгээр өгсөн бүтэц, орон тооны жишгийг мөрдлөг болгон Орон нутгийн өмчийн газрын орон тоог төсөвтөө багтаан нэмэгдүүлэх.
5. Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай албан хаагчийг холбогдох мэргэжлийн сургалтад хамруулах арга хэмжээг зохион байгуулах
6. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн байгууллагуудад үүрэг болгож, хэрэгжилтийг хангуулах.
7. Төрийн үйлчилгээний ил тод байдалд хяналт тавих олон нийтийн хяналтын зөвлөлийг байгуулах.

Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймгийн салбар зөвлөлийн дарга П.Бат-Өлзийд

8. Аймгийн Засаг даргын харьяаны төрийн байгууллагуудад хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцож ажиллах.
9. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг хангаж, төрийн албан хаагчийн хувийн хэргийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах.
10. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар хэсгийн Салбар зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүргийн 3.6 дахь зүйлийн Хяналт тавих, аудит хийх хүрээнд заасан заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.
11. Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2¹⁷, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2, 3.4.3, 3.6.4 дэх заалтуудыг хэрэгжүүлж, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулах.
12. Мэргэжил, боловсрол, мэргэжлийн индекс таараагүй төрийн албан хаагчдыг албан тушаалын тодорхойлолтод нийцүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнах. /Тайлангийн 15-16 дугаар хуудас, хүснэгт №4/

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсний дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 12 дугаарын 20-ны дотор ирүүлнэ үү.

¹⁷ "Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана."



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/20

Чойбалсан хот

Г

Тайлан баталгаажуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймаг дахь салбар зөвлөл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох бусад байгууллагад тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Я.Зориг)-т даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010196

Тэргүүлэх аудиторын 2024 оны
11 дүгээр сарын 20-ны өдрийн
А/20 дугаар тушаалын хавсралт

Төлбөрийн актын жагсаалт

№	Байгууллагын нэр, албан тушаал	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн акт, албан шаардлагын утга	Мөнгөн дүн /төгрөгөөр/
1	Баяндун сумын Ерөнхий боловсролын сургууль	ГНАГ-2024/19- ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	389,400
2	Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар		Төлбөр барагдуулах тухай	180,000
3	Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар	ДОА-2024/19- 9-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	440,000
4	Байгаль орчин, аялал жуулчлалын газар		Төлбөр барагдуулах тухай	968,000
5	Сэргэлэн сумын цэцэрлэг		Төлбөр барагдуулах тухай	3,140,408
Нийт дүн				5,117,508

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр, албан тушаал	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн акт, албан шаардлагын утга	Мөнгөн дүн /сая.төг/
1	Аймгийн Засаг дарга	ГНАГ-2024/19- ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	-
2	ТАЗСЗ-ын дарга	ДОА-2024/19- 9-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	-
Нийт дүн				

---oOo---

